



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

Дундговь аймгийн Боловсролын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код:** Аудитын код 2022/21/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Мандалговь хот

2022 он

Дарга, тэргүүлэх аудитор:

Р.МӨНХТОГТОХ

Утас: 70592439

Цахим хаяг: [MunkhtogtokhR@audit.gov.mn](mailto:MunkhtogtokhR@audit.gov.mn)

Аудитын менежер:

Х.НАРАНЦАЦРАЛ

Утас: 70592225

Цахим хаяг: [Narantsatsralkh@audit.gov.mn](mailto:Narantsatsralkh@audit.gov.mn)

Ахлах аудитор:

Т.БАТСАЙХАН

Утас: 70593113

Цахим хаяг: [biligmunkhujin@gmail.com](mailto:biligmunkhujin@gmail.com)

## Агуулга

---

1. Аудитын гэрчилгээ .....	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	4
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан төгрөгөөр .....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	8
3. Аудитын тайлан.....	9
3.1 Ерөнхий зүйл.....	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	10
3.4 Материаллаг байдал.....	10
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....	12
3.8 Аудитын гол асуудал .....	12
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	12
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	13
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	13
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	13
4. Аудитын илрүүлэлт.....	13
4.1 Залруулсан алдаа.....	13
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	14

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт

**Аудитын гэрчилгээ**



**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон, 7-р баг, Сайнцагаан сум  
Дундговь аймаг 48090 Утас: 70592439, 70592208,  
70593208, Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn

2022.08.25 № 52

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**ДУНДГОВЬ АЙМГИЙН  
БОЛВСРОЛЫН ДАРГА  
Ц.УРАНБЯМБА ТАНАА**

**АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ**

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дундговь аймгийн Боловсролын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дундговь аймгийн Боловсролын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**


Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

0012020806

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа  
эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн  
шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Р.МӨНХТОГТОХ

## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Төгрөгөөр/ Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>26,899,337.47</u></b>	<b><u>29,264,361.94</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	4,322,383.00	3,727,646.90
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	4,322,383.00	3,727,646.90
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	4,322,383.00	3,727,646.90
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	4,322,383.00	3,727,646.90
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	2,961,818.43	1,850,000.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	1,850,000.00	1,850,000.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	1,850,000.00	1,850,000.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	19,615,136.04	23,686,715.04
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	7,097,221.04	7,097,221.04
35110	Тусгай зориулалттай материал	7,097,221.04	7,097,221.04
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	12,517,915.00	16,589,494.00
35410	Бичиг хэргийн материал	3,491,630.00	3,446,985.00
35420	Аж ахуйн материал	6,401,585.00	10,474,509.00
35430	Сэлбэг хэрэгсэл	883,000.00	883,000.00
35450	Барилгын засварын материал	1,741,700.00	1,785,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>451,120,258.46</u></b>	<b><u>540,991,998.92</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	451,120,258.46	540,991,998.92
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	451,120,258.46	540,991,998.92
39201	Барилга, байгууламж, орон сууц	437,861,641.04	520,630,937.04
39202	Хуримтлагдсан элэгдэл	(26,963,696.15)	(35,179,233.23)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	56,600,000.00	56,600,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(23,000,000.00)	(29,720,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	151,210,006.12	125,684,729.25
39206	Хуримтлагдсан элэгдэл	(148,033,982.92)	(99,270,813.40)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	32,632,388.64	32,632,388.64
39208	Хуримтлагдсан элэгдэл	(29,186,098.27)	(30,386,009.38)
39301	Програм хангамж	1,685,000.00	1,685,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,685,000.00)	(1,685,000.00)
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>478,019,595.93</u></b>	<b><u>570,256,360.86</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>2,093,657.91</u></b>	<b><u>5,490,398.56</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	2,093,657.91	5,490,398.56
<b>413</b>	<b>Өглөг</b>	2,093,657.91	5,490,398.56
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	596,911.92	3,505,572.52
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	1,016,757.99	1,504,838.04
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	479,988.00	479,988.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	479,988.00	479,988.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>475,925,938.02</u></b>	<b><u>564,765,962.30</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	475,925,938.02	564,765,962.30
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	387,540,211.70	387,540,211.70
51101	Өмч: - төрийн	387,540,211.70	387,540,211.70
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	(58,455,045.18)	31,384,750.77
51210	Өмнөх үеийн үр дүн	(73,607,508.27)	(57,455,273.51)
51220	Тайлант үеийн үр дүн	15,152,463.09	88,840,024.28
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	146,840,771.50	145,840,999.83
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>478,019,595.93</u></b>	<b><u>570,256,360.86</u></b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны	Үзүүлэлт	Өмнөх оны	Тайлант оны Төгрөгөөр/
--------	----------	-----------	---------------------------

Дундговь аймгийн Боловсрол газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

код		гүйцэтгэл	гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,337,225,788.86</b>	<b>1,659,324,589.90</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>77,242,374.86</b>	<b>93,001,165.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	77,242,374.86	93,001,165.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	77,242,374.86	93,001,165.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	384,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	77,242,374.86	92,617,165.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,259,983,414.00</b>	<b>1,566,323,424.90</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	1,250,857,700.00	1,382,076,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,250,857,700.00	1,382,076,900.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	9,125,714.00	184,246,524.90
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,433,300.00	174,533,181.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	5,692,414.00	9,713,343.90
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,322,073,325.77</b>	<b>1,570,308,565.62</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,322,073,325.77</b>	<b>1,570,308,565.62</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	363,738,605.57	482,191,838.28
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	209,971,431.00	214,819,679.03
210101	Үндсэн цалин	149,507,505.34	167,777,676.03
210102	Нэмэгдэл	42,445,256.00	29,195,181.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	10,064,998.66	8,355,766.00
210104	Урамшуулал	7,953,671.00	9,491,056.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	25,920,038.51	27,058,770.48
210201	Тэтгэврийн даатгал	17,583,875.91	18,957,931.15
210202	Тэтгэмжийн даатгал	2,092,199.58	2,109,694.86
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,673,699.86	1,687,755.37
210204	Ажилгүйдлийн даатгал	385,864.00	391,217.66
210205	Эрүүл мэндийн даатгал	4,184,399.16	3,912,171.44
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	30,277,699.20	30,737,600.00
210301	Гэрэл, цахилгаан	5,658,287.20	2,083,927.10
210302	Түлш, халаалт	22,153,600.00	26,649,672.90
210303	Цэвэр, бохир ус	2,465,812.00	2,004,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	50,740,925.45	26,590,841.23
210401	Бичиг хэрэг	5,444,150.00	10,952,569.00
210402	Тээвэр, шатахуун	2,619,762.00	4,516,260.05
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	700,028.99	671,722.18
210404	Ном, хэвлэл	207,200.00	36,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	170,400.00	9,871,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	561,950.00	543,190.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	-	17,305,300.00
210602	Тавилга	-	15,000,000.00
210604	Урсгал засвар	-	2,305,300.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	1,198,000.00	556,900.00
210702	Дотоод албан томиллолт	1,198,000.00	556,900.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	5,577,302.00	125,271,712.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,577,302.00	125,271,712.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	40,053,209.41	39,851,035.54
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,811,600.00	6,139,380.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	23,055,016.89	16,116,890.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	13,186,592.52	17,594,765.54
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	958,334,720.20	1,088,116,727.34
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	907,167,648.00	1,064,266,308.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	386,346,948.00	653,350,019.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай	520,410,700.00	410,588,289.00

Дундговь аймгийн Боловсрол газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

	ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	410,000.00	328,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>51,167,072.20</b>	<b>404,200.00</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	51,167,072.20	404,200.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	-	23,446,219.34
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	23,446,219.34
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>15,152,463.09</b>	<b>89,016,024.28</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	-	176,000.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	176,000.00
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	-	(176,000.00)
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>15,152,463.09</b>	<b>88,840,024.28</b>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>1,272,098,912.89</b>	<b>1,566,767,424.90</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	-	<b>384,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	-	384,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	384,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	384,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,272,098,912.89</b>	<b>1,566,383,424.90</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	1,250,857,700.00	1,382,076,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,250,857,700.00	1,382,076,900.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	21,241,212.89	184,306,524.90
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,433,300.00	174,533,181.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	17,807,912.89	9,773,343.90
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>1,271,850,998.89</b>	<b>1,551,719,546.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,271,850,998.89</b>	<b>1,551,719,546.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>313,456,278.69</b>	<b>463,602,818.66</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	209,221,100.00	210,859,200.00
210101	Үндсэн цалин	148,757,174.34	163,817,197.00
210102	Нэмэгдэл	42,445,256.00	29,195,181.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	10,064,998.66	8,355,766.00
210104	Урамшуулал	7,953,671.00	9,491,056.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	28,211,760.60	27,058,770.48
210201	Тэтгэврийн даатгал	19,875,598.00	18,957,931.15
210202	Тэтгэмжийн даатгал	2,092,199.58	2,109,694.86
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,673,699.86	1,687,755.37
210204	Ажилгүйдлийн даатгал	385,864.00	391,217.66
210205	Эрүүл мэндийн даатгал	4,184,399.16	3,912,171.44
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	29,096,899.20	30,737,600.00
210301	Гэрэл, цахилгаан	5,658,287.20	2,083,927.10
210302	Түлш, халаалт	20,972,800.00	26,649,672.90
210303	Цэвэр, бохир ус	2,465,812.00	2,004,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	5,492,800.00	20,508,871.18
210401	Бичиг хэрэг	521,800.00	4,786,429.00
210402	Тээвэр, шатахуун	3,318,500.00	4,516,260.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	622,600.00	715,942.18
210404	Ном, хэвлэл	207,200.00	164,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	370,800.00	9,902,040.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	451,900.00	424,200.00

Дундговь аймгийн Боловсрол газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	-	20,705,985.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	3,357,385.00
210602	Тавилга	-	15,000,000.00
210604	Урсгал засвар	-	2,348,600.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	1,198,000.00	556,900.00
210702	Дотоод албан томилолт	1,198,000.00	556,900.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	7,269,302.00	125,446,612.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,269,302.00	125,446,612.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	32,966,416.89	27,728,880.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,811,600.00	6,139,380.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	29,154,816.89	21,589,500.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>958,394,720.20</b>	<b>1,088,116,727.34</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	907,167,648.00	1,064,266,308.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	386,346,948.00	653,350,019.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	520,410,700.00	410,588,289.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	410,000.00	328,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	51,227,072.20	404,200.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	51,227,072.20	404,200.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	-	23,446,219.34
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	23,446,219.34
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>247,914.00</b>	<b>15,047,878.90</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	-	<b>15,642,615.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	-	<b>15,642,615.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	-	15,642,615.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	15,642,615.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	=	<b>(15,642,615.00)</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	247,914.00	(594,736.10)
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	4,074,469.00	4,322,383.00
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	4,322,383.00	3,727,646.90

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	/ төгрөгөөр / Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	387,540,211.70	146,840,771.50	-73,607,508.27	460,773,474.93
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	<b>387,540,211.70</b>	<b>146,840,771.50</b>	<b>-73,607,508.27</b>	460,773,474.93
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	15,152,463.09	15,152,463.09
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	<b>387,540,211.70</b>	<b>146,840,771.50</b>	<b>-58,455,045.18</b>	475,925,938.02
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	<b>387,540,211.70</b>	<b>146,840,771.50</b>	<b>-58,455,045.18</b>	475,925,938.02

Дундговь аймгийн Боловсрол газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	999,771.67	999,771.67
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>387,540,211.70</b>	<b>146,840,771.50</b>	<b>-57,455,273.51</b>	476,925,709.69
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	-999,771.67		-999,771.67
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	88,840,024.28	88,840,024.28
D09	<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>387,540,211.70</b>	<b>145,840,999.83</b>	<b>31,384,750.77</b>	564,765,962.30

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

				/ төгрөгөөр /	
Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө		Гүйцэтгэл	
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	1,382,076,800.00		1,359,014,680.66	
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	1,382,076,800.00		1,359,014,680.66	
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	296,156,400.00		294,748,372.66	
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	210,859,200.00		210,859,200.00	
210101	Үндсэн цалин	155,123,200.00		163,817,197.00	
210102	Нэмэгдэл	42,367,500.00		29,195,181.00	
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9,504,000.00		8,355,766.00	
210104	Урамшуулал	3,864,500.00		9,491,056.00	
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	28,465,900.00		27,058,770.48	
210201	Тэтгэврийн даатгал	20,097,100.00		18,957,931.15	
210202	Тэтгэмжийн даатгал	2,092,200.00		2,109,694.86	
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,673,800.00		1,687,755.37	
210204	Ажилгүйдлийн даатгал	418,400.00		391,217.66	
210205	Эрүүл мэндийн даатгал	4,184,400.00		3,912,171.44	
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	30,737,600.00		30,737,600.00	
210301	Гэрэл, цахилгаан	2,080,000.00		2,083,927.10	
210302	Түлш, халаалт	26,653,600.00		26,649,672.90	
210303	Цэвэр, бохир ус	2,004,000.00		2,004,000.00	
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	6,244,400.00		6,243,502.18	
210401	Бичиг хэрэг	340,300.00		252,160.00	
210402	Тээвэр, шатахуун	4,482,900.00		4,516,260.00	
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	529,200.00		715,942.18	
210404	Ном, хэвлэл	192,700.00		164,000.00	
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	315,200.00		170,940.00	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	384,100.00		424,200.00	
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	2,348,600.00		2,348,600.00	
210604	Урсгал засвар	2,348,600.00		2,348,600.00	
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	556,900.00		556,900.00	
210702	Дотоод албан томилолт	556,900.00		556,900.00	
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	1,102,200.00		1,102,200.00	
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,102,200.00		1,102,200.00	
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	15,841,600.00		15,841,600.00	
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	241,600.00		241,600.00	
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	15,600,000.00		15,600,000.00	

<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	1,085,920,400.00	1,064,266,308.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	1,085,920,400.00	1,064,266,308.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	668,293,000.00	653,350,019.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	417,299,400.00	410,588,289.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	328,000.00	328,000.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	1,382,076,900.00	1,382,460,900.00
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	-	1,382,076,900.00
131001	Улсын төсвөөс санхүүжих		1,382,076,900.00
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	-	384,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		384,000.00

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл / төгрөгөөр /
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>184,901,261.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>184,901,261.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	184,497,061.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	14,265,369.00
210401	Бичиг хэрэг	4,534,269.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	9,731,100.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	34,000,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	19,000,000.00
210602	Тавилга	15,000,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	124,344,412.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	124,344,412.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	11,887,280.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,897,780.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,989,500.00
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>404,200.00</b>
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	404,200.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	184,306,524.90
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	184,306,524.90
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	174,533,181.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	9,773,343.90
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	<b>(594,736.10)</b>
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	4,322,383.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	3,727,646.90

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” заасны дагуу Дундговь

аймгийн Боловсролын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Аудитын 1 дүгээр нэгжийн ахлах аудитор Т.Батсайхан гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Наранцацрал, газрын дарга, тэргүүлэх аудитор Р.Мөнхтогтох нар тус тус хэрэгжүүлсэн.

Дундговь аймгийн Боловсролын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дундговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 13 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

Дундговь аймгийн Боловсролын газар нь зорилгоо “Хөгжлийн чиг хандлага, нийгэм, соёлын үнэт зүйл, хэрэгцээнд нийцүүлэн боловсрол, соёлын бодлогын үр нөлөөг дээшлүүлэн олон талт чанартай үйлчилгээг тэгш хүртээмжтэй хүргэх замаар эрүүл чийрэг, зөв дадалтай бүтээлч сэтгэлгээтэй бие даан суралцах насан туршдаа хөгжих чадвартай, эх оронч иргэнийг төлөвшүүлэхэд оршино” гэж тодорхойлжээ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзсэнээр дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант хугацаанд дотоод хяналт, шалгалт хийгдээгүй.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дундговь аймгийн Боловсролын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн

нийт зардлаас сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 667,63767 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 6,676.4 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 4,711.2 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Төлөвлөлтийн шатанд 2021 оны 2 дугаар улирлын санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаас 1 хувиар буюу 6,676.4 мянган төгрөгөөр тогтоосныг гүйцэтгэлийн шатанд 2021 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаас 1 хувиар буюу 15,703.1 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 70 хувиар буюу 10,992.2 мянган төгрөгөөр тооцон шинэчлэн тогтоолоо.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Дундговь аймгийн Боловсролын газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 92,236.8 мянган төгрөгөөр өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс бараа материалын данс материаллаг томоохон өөрчлөлт гараагүй байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөг/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	4,322.4	3,727.6	(594.8)
Авлага	2,961.8	1,850.0	(1,111.8)
Бараа материал	19,615.1	23,686.7	4,071.6
Үндсэн хөрөнгө	451,120.2	540,992.0	89,871.8
<b>Нийт хөрөнгө</b>	<b>478,019.5</b>	<b>570,256.3</b>	<b>92,236.8</b>
<b>Өр төлбөр</b>	<b>2,093.6</b>	<b>5,490.4</b>	<b>3,396.8</b>
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	475,925.9	564,765.9	88,840.0
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>478,019.5</b>	<b>570,256.3</b>	<b>92,236.8</b>

Бараа материал дансны үлдэгдэл 23,686.7 мянган төгрөг болж, өмнөх оноос 4,071.6 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр худалдан авсан 15,222.8 мянган төгрөг, хандив тусламжаар 34,738.2 мянган төгрөг, нийт 49,961.1 мянган төгрөгийн аж ахуйн материалын өсөлт нөлөөлсөн байна.

Төсвийн өөрийн хөрөнгөөр 15,642.6 мянган төгрөгийн хөрөнгийг худалдан авч, Дэлхий зөн олон улсын байгууллага татан буугдсантай холбоотой хандивын гэрээгээр 82,769.2 мянган төгрөгийн барилга, 9,230.5 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийн үнэ төлбөргүй хүлээн авч үндсэн хөрөнгийн дансанд тус тус бүртгэжээ. 50,398.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж бүртгэлээс хассан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 564,765.9 мянган төгрөг болж 88,840.0 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны үр дүнгээс шалтгаалжээ.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,380,804.4 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1,380,804.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 1,272.5 мянган төгрөгөөр өсгөж 1,382,076.9 мянган төгрөгөөр баталсан байна.

### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,382,076.9 мянган төгрөгийн төсөв баталж, улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,382,076.9 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 1,359,014.7 мянган төгрөгийг зарцуулж, 23.446.2 улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна. Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 99.9 хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр тайлангийн 2.5-д харуулав.

### **3.6.3 Нэмэлт төсвийн гүйцэтгэл**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсөв захирагчаас 174,533.2 мянган төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 9,773.3 мянган төгрөг, ахмадын сангийн эхний үлдэгдэл 594.7 мянган төгрөг нийт 184,901.2 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс хангамж бараа материалын зардалд 14,265.4 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардалд 34,000.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 124,344.4 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 11,887.2 мянган төгрөг нийт 184,497.1 мянган төгрөгийг зарцуулж, 404.2 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Төсвийн өөрийн хөрөнгөөр 15,642.6 мянган төгрөгийн хөрөнгийг худалдан авч, Дэлхийн зөн олон улсын байгууллага татан буугдсантай холбоотой хандивын гэрээгээр 82,769.2 мянган төгрөгийн барилга, 9,230.5 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийн үнэ төлбөргүй хүлээн авч үндсэн хөрөнгийн дансанд тус тус бүртгэжээ.

Нэмэлт санхүүжилтээр Боловсролын яамнаас боловсролын чанарын шинэчлэл төслийн хүрээнд ирсэн 124,344.4 мянган төгрөгийн санхүүжилтийг сумдын сургуулиудад сургалтын үйл ажиллагаанд зориулагдсан хэрэглэгдэхүүнд зарцуулсан байна.

### **3.8 Аудитын гол асуудал**

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдал байхгүй тул гол асуудал байхгүй гэж үзлээ.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх

дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 20 төрлийн мэдээллийг шилэн дансны цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Дундговь аймгийн Боловсролын газар нь 2021 онд нийт цахим системд мэдээлэл оруулах 1,566,767.4 мянган төгрөгийн 163 мэдээллээс 161 мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд ил тод, бүрэн байршуулж 2 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар 8,061.6 мянган төгрөгийн албан шаардлагыг хэрэгжүүлж ажилласан байна.

### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дундговь аймгийн Боловсролын газрын 2021 оны санхүүгийн тайланд анхаарал татахуйц асуудал илрээгүй.

Цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан үндсэн хөрөнгө, бараа материалын дансанд завсрын аудитаар хяналтын тооллого хэрэгжүүлэхээр шийдвэрлэлээ.

## **4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 4,225.6 мянган төгрөгийн алдаа илрүүлж, аудитын явцад санхүүгийн тайланд 1,947.9 мянган төгрөгийн алдааг залруулж, 646.9 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлж, 1,630.8 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоолоо.

### **4.1 Залруулсан алдаа**

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Тээвэр шатахууны 1,947.9 мянган төгрөгийн зардлыг шууд зардлаар тайлагнасан.

*Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд 1,947.9 мянган төгрөгийн залруулга хийсэн.*

### **4.2 Төлбөрийн акт**

Аудитаар илэрсэн дараах зөрчилд төлбөрийн акт тогтоолоо. Үүнд:

1. Тайланд тусгаагүй 1,180.8 мянган төгрөгийн өглөгийг түлш халаалтын зардлаас төлсөн.
2. Цалингийн урьдчилгаа 450.0 мянган төгрөгийг суутгаагүй.

*Шийдвэрлэсэн нь: Дээрх зөрчилд 1,630.0 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоосон.*

### **4.3 Албан шаардлага**

2. Санхүүгийн үр дүнгийн тайланд 646.9 мянган төгрөгийн цалингийн зардлыг дутуу тайлагнасан.

Шийдвэрлэсэн нь: Дээрх 646.9 мянган төгрөгийн зөрчлийг арилгах хугацаатай албан шаардлага хүргүүлсэн.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөг/

д/д	Алдаа, зөрчлийн агуулга	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>1. Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн хүрээнд:</b>											
<b>2. Бусад батламж мэдэгдлийн хүрээнд:</b>											
1	Тайланд тусгаагүй өр төлбөрийг түлш халаалтын зардлаас төлсөн.					1	1,180.8				
2	Үр дүнгийн тайланд цалингийн зардлыг дутуу тайлагнасан.							1	646.9		
3	Тээвэр шатахууны зардлыг шууд зардлаар тайлагнасан.			1	1,947.9						
4	Цалингийн урьдчилгаа суутгаагүй.					1	450.0				
	Нийт зөрчлийн дүн	4	4,225.6	1	1,947.9	1	1,630.8	2	646.9		